Умайн хүзүүний өмөнгийн эрт үе шатанд хийгдсэн эрхтэн хадгалах мэс заслын эмчилгээний дараах нөхөн үржихүйн үйл ажиллагааг үнэлсэн нь

Н.Баасансүрэн[1], Г.Ням-Од[1], М.Еркебулан[2], Д.Авирмэд[1], Э.Амарсанаа[1]
№Хавдар Судлалын Үндэсний Төв
АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль
baska523@yahoo.com

Түлхүүр үг
Умайн хүзүүний эрт үеийн өмөн, эрхтэн хадгалах, нөхөн үржихүй

Товч утга
Умайн хүзүүний өмөнгийн үе шатны ангилал эдийн түвшинд сайжирч байгаа нь эмчилгээний арга барилд өөрчлөлт гарч эрхтэн хадгалах мэс засал хөгжих боломж бүрдүүлдэг. Үүний үр дүнд Умайн хүзүүний өмөнгийн эрт үед оношлогдсон хүүхэд төрүүлэх хүсэлтэй залуу эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн чадварыг хадгалах мэс засал хийж байна. Нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслын аргад умайн хүзүүг шаантаг хэлбэрээр тайрах, умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлөх аргууд багтана. 2000 оноос манай оронд умайн хүзүүний эмгэгийг цахилгаан гогцоогоор өөлөх болон хутгаар шаантаг хэлбэрээр тайрах эмчилгээний аргуудыг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд амжилттай хэрэглэж байна. Агшингийн судалгааны загвараар 2013 оны 1 дүгээр сараас 2018 оны хооронд Хавдар Судлалын Үндэсний Төвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг (ЭМЗТ) болон Эрдэм Шинжилгээний Сургалт Мэдээллийн Төвийг (ЭШСМТ) түшиглэн хийж гүйцэтгэлээ. Судалгаанд 2013 оны 1 сараас 2015 оны 5 сарын хооронд умайн хүзүүний эрт үеийн өмөнгийн улмаас эрхтэн хадгалах мэс засал хийлгэсэн нөхөн үржихүйн насны буюу 19-45 насны эмэгтэйчүүдэд харьцуулан дүн шинжилгээ хийж судаллаа. Үр дүнг SPSS 25.0 программаар боловсруулав. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 45% нь төрөлт төрөх замаар төрж, 55% нь кесар мэс заслаар төрөлт шийдэгдсэн байна. Дүгнэлт: Эрхтэн хадгалах мэс засал эмчилгээ нь сарын тэмдгийн мөчлөг, жирэмслэлт болон төрөх үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхгүй байна (p>0.05).

Үндэслэл

Дэлхийн хүн амын дунд халдварт бус өвчний (ХБӨ) тархалт хурдацтай нэмэгдэж, хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны тэргүүлэх тулгамдсан асуудлын нэг болоод байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) мэдээлснээр 2018 оны байдлаар дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдэд тохиолдох хорт хавдрын дотор умайн хүзүүний өмөн нь хөх, шлуун гэдэс, уушигны өмөнгийн дараа дөрөвдүгээр байранд ордог хэмээжээ№. Үндэсний хэмжээний хорт хавдрын бүртгэлийн 2019 оны мэдээгээр умайн хүзүүний өмөн нь Монгол улсад зонхилон тохиолдож буй өмөнгийн 5.5 % буюу тохиолдлын тоогоороо тавдугаарт, нас баралтын (7.3%) гуравдугаарт, нөхөн үржихүйн эрхтний өмөнгийн дотор эхний байрт орж байна. Умайн хүзүүний өмөнгийн үе шатны ангилал эдийн түвшинд сайжирч байгаа нь эмчилгээний арга барилд өөрчлөлт гарч эрхтэн хадгалах мэс засал хөгжих боломж бүрдүүлдэг. Үүний үр дүнд УХӨ-ийн эрт үед оношлогдсон хүүхэд төрүүлэх хүсэлтэй залуу эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн чадварыг хадгалах мэс засал хийж байна. Нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслын аргад умайн хүзүүг шаантаг хэлбэрээр тайрах, цахилгаан гогцоогоор өөлөх аргууд багтана. 2000 оноос манай оронд умайн хүзүүний эмгэгийг цахилгаан гогцоогоор өөлөх болон хутгаар шаантаг хэлбэрээр өөлөх, умайн хүзүүг бүхэлд нь тайрч авах эмчилгээний аргуудыг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд амжилттай хэрэглэж байна. Эдгээр эмчилгээний

аргуудын үр дүнг тооцож эрхтэн хадгалах мэс засал эмчилгээ хийлгэсэн эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үйл ажиллагааны байдлыг судлах, практик ач холбогдлыг үнэлсэн судалгааны ажил манай оронд байхгүй байгаа нь энэхүү судалгааны ажлыг хийх үндэслэл болсон юм.

Зорилго, зорилт

Умайн хүзүүний өмөнгийн эрт үе шатанд хийгддэг эрхтэн хадгалах мэс заслын эмчилгээний дараах нөхөн үржихүйн үйл ажиллагааг судлах

1. Нөхөн үржихүйн үйл ажиллагааг хадгалах мэс засал эмчилгээний аргуудын хүндрэлийг харьцуулан судлах
2. Эрхтэн хадгалах эмчилгээний дараах нөхөн үржихүйн үйл ажиллагааг харьцуулан судлах

Арга аргачлал

ХСҮТ-ийн эмэгтэйчүүдийн мэс заслын тасагт 2013-2014 оны хооронд умайн хүзүүний эрт үеийн өмөнгөөр оношоор мэс засалд орсон 334 өвчтөний өвчний түүхэнд ретроспектив судалгааг хийсэн үр дүнгээс 116 өвчтөнийг аналитик судалгааны агшингийн аргаар судлагааг хийсэн.

Үр дүн

Эрхтэн хадгалах мэс засал эмчилгээний үр дүнгийн чухал асуудлын нэг нь эмэгтэйн нөхөн үржихүйн үйл ажиллагаан дахь нөлөөллийг судлах асуудал билээ. Судалгаанд хамрагдсан нийт 19-45 насны эмэгтэйчүүдийн сарын тэмдгийн байдал, жирэмслэлт, жирэмсний явц, төрлөгийн онцлогийг нарийвчлан судалж үр дүнг дараах дараах хүснэгтэнд тусган харууллаа.

Хүснэгт 1. Нөхөн үржихүйн үйл ажиллагааны байдал

Үзүүлэлт	Нийт	LEEP		Conization		P утга
n (%)	n (%)	95%	n (%)	95%		
Хагалгааны дараах биений юмны өөрчлөлт						0.458
Хэвийн	102 (87.9)	19 (95)	78.9 - 99.5	83 (86.5)	78.6 - 92.2	
Өөрчлөлттэй	14 (12.1)	1 (5)	0.5 - 21.1	13 (13.5)	7.8 - 21.4	
Хагалгаанаас өмнө зулбасан эсэх						NS
Тийм	21 (100)	1 (100)		20 (100)		
Үгүй	0 (0)	0 (0)		0 (0)		
Хагалгааны дараа зулбасан эсэх						NS
Тийм	5 (71.4)	0 (0)		5 (71.4)	35.2 - 93.5	
Үгүй	2 (28.6)	0 (0)		2 (28.6)	6.5 - 64.8	
Жирэмслэсэн эсэх						0.731
Тийм	61 (89.7)	12 (92.3)	69.3 - 99.2	49 (89.1)	78.9 - 95.3	
Үгүй	7 (10.3)	1 (7.7)	0.8 - 30.7	6 (10.9)	4.7 - 21.1	
Төрөлтийн хэлбэр						**0.02**
Төрөөгүй	0 (0)	0 (0)		0 (0)		
Өөрөөрөө төрсөн	28 (45)	9 (75)	47.1 - 92.4	18 (37.5)	24.9 - 51.6	
Кесароваар төрсөн	33 (55)	3 (25)	7.6 - 52.9	30 (62.5)	48.4 - 75.1	

Хүснэгтээс харахад нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс засал хийлгэсэн өвчтний цэвэршилтийн өмнөх насны эмэгтэйчүүдийн 87.9%-д биений юм хэвийн үргэлжилж мэс засал эмчилгээний дараа 89.7% нь жирэмсэлсэн болно. Мэс засал эмчилгээний арга тус бүрээр авч үзэхэд умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлөх мэс засал хийлгэсэн эмэгтэйчүүдийн 92.3%, умайн хүзүүг хутгаар шаантаг хэлбэрээр тайрах мэс заслын дараа 89.1% нь жирэмсэлсэн байна. Ургийн тээлтэнд хагалгаа хэрхэн нөлөөлж байгааг хагалгааны өмнөх ба дараах түүврээс судлахад умайн хүзүүг шаантаг хэлбрээр тайрах мэс засал хийлгэсэн нийт өвчтнүүдийн 20 нь мэс заслын өмнө зулбаж байсан бол мэс заслын дараах 5 жилд 5 зулбалт бүртгэгджээ. Цахилгаан гогцоогоор өөлөх мэс засал хийлгэсэн өвчтнүүдээс мэс заслын өмнө 1 эмэгтэй зулбаж байсан бол

мэс заслын дараах 5 жилийн байдлаар зулбасан тохиолдол гараагүй байна. Бид жирэмсний тээлтийн хугацаа гүйцсэн эмэгтэйчүүдийн төрлөг хэрхэн шийдэгдсэн байдлыг судлахад судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 45% нь хэвийн төрж, 55% нь кесар мэс заслаар төрөлт шийдэгдсэн байна (p=0.02).

Хэлцэмж

Судлаач Myllynenба L Karjalainen.O нар CIN оноштой 84 эмэгтэйн хагалгааны дараах 109 жирэмслэлтийн тохиолдлыг хагалгааны өмнөх 204 жирэмслэлтийн тохиолдолтой харьцуулан судалжээ. Судалгаагаар хожуу зулбалт болон дутуу төрөлт умайн хүзүүг тайрах хагалгааны дараа илүү тохиолдоно (p<0.001), жирэмсний эрт үеийн зулбалт нь 2 бүлэгт адил байв. Судлаачид хагалгаанд орсон эмэгтэйчүүдийн нас нь их байх тусам жирэмсний явцад сөргөөр нөлөөлж байгааг ажиглажээ. Мөн умайн хүзүүг тайрах хагалгаа нь кесар хагалгааны тоонд нөлөөлж байгаа судалгаагаар харуулсан. Хагалгааны дараа 25.5%, хагалгааны өмнөх кесар 14.6% эзэлжээ. Иймд умайн хүзүүг өөлөх хагалгаа нь дараачийн жирэмслэлтэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болох ба уг өвчтнүүдийг хяналтанд авахыг зөвлөжээ. Бидний судалгаагаар умайн хүзүүг хутгаар тайрах мэс засал хийлгэсэн эмэгтэйчүүдийн 62.5 % нь кесар мэс заслаар төрж байгаа дээрхи судалгааны үр дүнтэй ойролцоо байна гэж үзэж байна. Sheila Wenmann, Allison Naleway[4] нарын судлаачдын судалгаагаар умайн хүзүүг тайрах мэс засал нь бага жинтэй хүүхэд гаргах болон дутуу төрөлттэй хамааралтай (RR=2.15, 95% CL 1.16-3.98) боловч энэхүү мэс засал нь кесар мэс засалтай хамааралгүй гэж харуулжээ. Бидний судалгаагаар умайн хүзүүг тайрах мэс засал нь зулбалттай төдийлөн хамааралгүй ч энэхүү хагалгаа нь кесар мэс засалтай хамааралтай гэж харуулж байна (p>0.05). Megumi Furugori, Mikiko Asai-Sato[5] нарын судалгаанд нийт эмэгтэйчүүдийн 45.1 хувь буюу 37 эмэгтэйд биений юм өмнөхөөс илүү их хэмжээтэй ирдэг болсон ба 22.7 хувь буюу 20 тохилдолд биений юм өвдөлттэй ирдэг гэж ажиглагдсан байна. Бидний судалгаагаар энэхүү мэс засал нь биений юмны мөчлөгт сөргөөр нөлөөлөхгүй байгаа нь ажиглагдсан. Chia-Yi Lee, Yu-Li Chen[6] нарын судалгаагаар нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс засал хийлгэсэн 30 эмэгтэйчүүдээс 15 нь жирэмсэлж үүнээс 11 нь амжилттай хүүхэд төрүүлсэн байна. (73.3%) Linsay[7] et al. нарын судалгаагаар 43 эмэгтэйчүүдээс амжилттай хүүхдээ тээж төрүүлсэн нь 42% байгаа нь бидний судалгааны үр дүнтэй (89.7%)ойролцоо байна гэж үзэж байна.

Дүгнэлт

Умайн хүзүүг шаантаг хэлбэрээр тайрах мэс засал хүндрэл багатай үр дүнтэй мэс заслын арга гэж дүгнэж байна. Нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс засал нь нөхөн үржихүйн үйл ажиллагааг хадгалах боломжийг олгож байна. Мэс заслын аргуудыг харьцуулан судлахад умайн хүзүүг шаантаг хэлбэрээр тайрах мэс засал нь дутуу төрөлтөнд нөлөөлж байна. Төрөлт шийдэгдсэн байдал умайн хүзүүг цахилгаан гогцоогоор өөлөх мэс засал нь төрөх замаар төрөх, умайг хүзүүг шаантаг хэлбэрээр тайрах мэс засал нь кесар мэс заслаар төрөх тоог нэмэгдүүлж байна.

Талархал

Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн ХСҮТ-ийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эмч нар болон АШУҮИС-ийн Эрдмийн сургуулийн эрдмийн судлалын тэнхимийн эрдэмтэн багш нарт талархал илэрхийлье.

Ном зүй

1. *Ferlay J, Soeromataram et al. Cancer incidence and mortality worldwide: Sources, methods and major patterns in GLOBOCAN 2018, Int J cancer, 2018;136.359-386.*
2. *ХСҮТ, Бүртгэл тандалт эрт илрүүлгийн алба Монгол улсын хорт хавдрын статистик тайлангийн үзүүлэлт 2019*
3. *Pregnancy outcome after combined amputation and conization of the uterine cervix. Myllynen L, et Gynaecologiae, 01 Jan 1984, 73(6):345-349*
4. *Sheila Wenmann, Allison Naleway, Geeta Swamy Girishanthy Krishnarajah8 Bhakti Arondekar. Pregnancy Outcomes after Treatment for Cervical Cancer Precursor Lesions: An Observational Study. One.2017 Feb13; 12(2)*
5. *Megumi Furugori[1,] et al. Short- and long-term complications and the impact on quality of life after cervical conization by harmonic scalpel. Pubmed. gov Obstet. Gynecol. 2017 Apr;43(4):749-757*
6. *Chia-Yi Lee, Yu-Li Chen , et al. Outcome and Subsequent Pregnancy after Fertility-Sparing Surgery of Early-Stage Cervical Cancers . Int. J. Environ. Res. Public Health 2020, 17, 710328*
7. *Lindsay, R.; Burton, et al. Fertility conserving management of early cervical cancer: Our experience of LLETZ and pelvic lymph node dissection. Int. J. Gynecol. Cancer 2014, 24, 118–123.*

Reproductive outcomes after conization for early-stage cervical cancer

Baasansuren N[1], Nyam-Od G[1], Yerkyebulan M[1], Avirmed D[1], Amarsanaa E[1],
[1]National Cancer Center, Gynecological Surgery Department
[2]School of Public Health, MNUMS
baska523@yahoo.com

ABSTRACT

Background: Updated pathological staging of cervical cancer which helps to increase the fertility sparing surgery options for cervical cancer patients. The main purpose of the treatment is to remove the cervical lesion with adequate surgical margins as well as the whole transformation zone. **Material and methodology:** Studying results of fertility sparing surgical treatments of early stage cervical cancer.This study was performed at the National Cancer Center in 2013-2018. We involved from 19 to 45 aged total 116 women, who diagnosed with early-stage cervical cancer. The data processing of the result was implemented by SPSS 25.0 program. **Results:** After the fertility sparing treatment 89.7% of patients reached pregnancy, 45% of patients who reached pregnancy had normal labor, and 55% had cesarean sections respectively.